



СЭЛЭНГЭ АЙМГИЙН УС, ЦАГ УУР,
ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВИЙН
ДАРГЫН ТУШААЛ

2026 оны 04 сарын 06 өдөр

Дугаар А/17

Сүхбаатар сум

Цаг агаарт зориудаар нөлөөлөх экспедиц
ажиллуулах, нэмэгдэл хөлс олгох тухай

Монгол улсын Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.4, 16.5.5, Хөдөлмөрийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.1, 56.2, 101 дүгээр зүйлийн 101.1, 102 дугаар зүйлийн 102.1.3, 108 дугаар зүйлийн 108.1, 109 дүгээр зүйлийн 109.5, 109.6, Цаг уур орчны шинжилгээний газрын даргын 2026 оны А/57 тоот тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1.Цаг агаарт зориудаар нөлөөлж хур тунадас нэмэгдүүлэх хөдөлгөөнт экспедицийн бие бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2.Цаг агаарт зориудаар нөлөөлж хур тунадас нэмэгдүүлэх үйл ажиллагааг 2026 оны 03 дугаар сарын 23-ны өдрөөс эхлэн 2026 оны 08 дугаар сарын 31-ний өдрийг дуустал хугацаанд явуулсугай.


3.Экспедицийн бие бүрэлдэхүүнд ажил гүйцэтгэсний нэмэгдлийг олгохдоо тухай сард гүйцэтгэсэн ажлын тайлан, үр дүнг үндэслэн үндсэн цалингийн 40 хүртэл хувиар тооцож олгох талаар сар бүрийн 25-ны дотор төвийн даргад танилцуулж шийдвэрлүүлж ажиллахыг Ерөнхий технологич инженер бөгөөд мэдээллийн сангийн зохицуулагч /Г.Энхзул/-д даалгасугай.

4.Хур тунадас нэмэгдүүлэх үйл ажиллагаа явуулахдаа Цаг уур орчны шинжилгээний газрын Улсын сүлжээ, уур амьсгалын үйлчилгээний хэлтсийн Цаг агаарт зориудаар нөлөөлөх албатай зөвшилцөх цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагааны аюулгүй байдлыг хангах талаар мөрдөж буй хууль, тогтоомж журам зааврыг чанд мөрдөн ажиллаж, ажлын гүйцэтгэл үр дүнгийн талаарх мэдээллийг холбогдох газарт шуурхай үнэн зөв мэдээлж байхыг экспедицийн дарга нарт даалгасугай.



О.ГАНБАТ

Ус цаг уур орчны шинжилгээний төвийн
даргын 2026 оны 04 дугаар сарын 06
өдрийн 114 тоот тушаалын хавсралт



**Цаг агаарт зориудаар нөлөөлж хур тунадас нэмэгдүүлэх
хөдөлгөөнт экспедицүүдийн бие бүрэлдэхүүний ажлыг
хавсран гүйцэтгэх ажилтнуудын жагсаалт**

1. М.Амарбаясгалан (Зэвсгийн инженер)
2. Д.Бүрэнтөгс (Зэвсгийн инженер)
3. П.Жигүүрцэцэг (Экспедицийн дарга)
4. Г.Энхзул (Экспедицийн дарга)
5. С.Сүлд-Эрдэнэ (Синоптик инженер)
6. Т.Түвшинжаргал (Синоптик инженер)
7. М.Урангоо (Синоптик инженер)
8. Г.Мөнгөнтуяа (Цаг уурын ажиглагч)
9. Д.Шүрэн-Эрдэнэ (Цаг уурын ажиглагч)
10. С.Хоролтогтох (Цаг уурын ажиглагч)
11. Р.Шинэбаяр (Цаг уурын ажиглагч)
12. М.Гантуяа (Нягтлан бодогч)
13. Ш.Уянга (Нярав)
14. Ц.Цэрэндорж (Зэвсгийн жолооч)
15. М.Төмөрхөлөг (Жолооч)